

1. “Захидал” сэдэвтэй холбоотойгоор МХ-УЗ-ын багшдаа чин сэтгэлийн захиа бичээд өөрийн гараар хийсэн дугтуйнд хийж өгнө. 10 оноо

Ач холбогдол нь:

- Техник технологийн эрин болсон өнөө цагт гараараа захидал бичин ,сэтгэл доторхоо нээн харилцдаг амьд холбоо тасарч байгааг сэргээн сануулах
- Ирэх 2 жилд сурагчид маань багшаас юу хүсэж байгаа болон тулгамдаж байгаа саад бэрхшээлээ илэн далангүй нээх
- Ингэснээр багш өөрийн үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийж, төлөвлөнө

2. Францын зохиолч Виктор Гюгогийн “Парисын Дарь эхийн сүм” жүжгийг 2015-04-19-нд 10-р ангийн сурагчид үзсэнтэй холбоотойгоор хүүхэд бүр А4-ийн хэмжээтэй цаасан дээр “Төрсөн сэтгэгдэл”-ээ бичиж өгнө. 10 оноо

Ач холбогдол нь:

- Үзсэн харсан, уншсан судалсан зохиол бүтээлдээ үнэлэлт дүгнэлттэй ханддаг болно
- Өөрийн үзэл бодлыг ЗБД болон Найруулгын алдаа багатайбичдэг болно
- Шугамгүй цаасан дээр гараараа бичсэнээр бичгийн соёл нь дээшилнэ

3. Анги бүрийн сурагчид 4-н багт хуваагдан

-В.Инжиннаш “Хөх судар” түүхэн судар роман

- С.Удвал “Их хувь заяа”түүхэн роман

- А.С.Пушкин “Евгений Онегин” шүлэглэсэн роман

- Ж.К.Роулинг”Харри Потер” уран сэтгэмжийн романуудаар бие даалт хийнэ. 20 оноо

Ач холбогдол нь:

- Туульсын зохиолын том төрөл зүйлийн ангилал, ялгааг мэдэж авах
- Сурах бичгийн хүрээнээс хальж интернэт орчноос мэдээлэл олж авах
- Эдгээр зохиолуудын тухай тодорхой хэмжээний мэдлэгийг бие даан олж авах
- Олж авсан мэдлэгээ үе тэнгийнхэдээ түгээн дэлгэрүүлэх
- Хэл ярианы чадвар нь сайжрах

4. Ц.Хулан “Аавдаа” шүлгийг чээжилж , дүгнүүлнэ . 10 оноо

Ач холбогдол нь:

- Авьяаслаг яруу найрагчийн сонгомол бүтээлтэй танилцах
- Монгол хэлнийхээ яруу тансаг үгийн баялгаас суралцах
- Ой тогтоолтыг дээшлүүлэх
- Өөрийнхөө бичвэрт эш баримт болгон ашиглах
- Хамгийн дотно хүмүүсийн нэг болох аавыгаа ойлгох, хүндэтгэх, хайрлах сэтгэлийг төлөвшүүлэх

5. Дэвтэр хөтлөлтийн үнэлгээ буюу идэвх . 40 оноо

6. Ирц. 10 оноо

Хүндэтгэх шалтгаангүйгээр хичээлд суугаагүй , хоцроогүй, дэвтэр , ном, цэнхэр балгүй бол тус бүр -1 оноогоор үнэлнэ

Эдгээрийг хийж. бүтээж,бичиж, гүйцэтгэж, чээжилснээр IV улирлаар Уран зохиолын хичээл дээр амжилттай дүгнэгдэх болно